

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

20 24 оны 04 сарын 29 өдөр

№ SR-2024-07

Улаанбаатар хот

ХасБанкинд ЕСБХБ-тай Фреймворк гэрээ байгуулах  
зөвшөөрөл олгох тухай

ХасБанк ХК (“ХасБанк”)-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлаар хэлэлцээд дараах шийдвэрийг гаргав:

**ТЭМДЭГЛЭХ нь:**

- ХасБанк болон түүний нийт гаргасан хувьцааны 94.99%-ийг нь эзэмшдэг толгой компани болох ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК (“ТСН”) нь Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэгт заасны дагуу аль нэг хувьцаа эзэмшигч дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмших хувьцааны хэмжээ нь банкны нийт гаргасан хувьцааны 20 хувиас хэтрэхгүй байх шаардлагыг хангасан байх шаардлагатай болохыг (“Хуулийн шаардлага”);
- ХасБанкны хувьцаа эзэмшигчид өмнө нь SR-2023-01 дүгээр тогтоол гаргаж, ХасБанк нээлттэй хувьцаат компани болж өөрчлөн байгуулагдсаны дараа ТСН-ийг ХасБанкинд нэгтгэх замаар энэхүү Хуулийн шаардлагыг хангах нь зүйтэй гэж үзсэн, нэгдлийн үр дүнд ХасБанк үйл ажиллагаагаа үргэлжлүүлж үлдэх ба ТСН-ийн хувьцаа эзэмшигчид ХасБанкны шууд хувьцаа эзэмшигчид болохыг (“Нэгтгэх өөрчлөн байгуулалт”);
- ТСН-ийн хувьцаа эзэмшигчид нь Нэгтгэх өөрчлөн байгуулалттай холбогдуулан, ХасБанкийг Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк (“ЕСБХБ”)-тай Фреймворк гэрээг Нэгтгэх гэрээнд гарын үсэг зурах өдөр эсхүл түүнээс өмнө байгуулсан нөхцөлд Нэгтгэх гэрээг байгуулахыг SGR-2024-03 дугаар тогтоолоороо шийдвэрлэсэн болохыг; мөн
- ХасБанк нь ЕСБХБ-тай Фреймворк гэрээг Нэгтгэх гэрээнд гарын үсэг зурах өдөр эсхүл түүнээс өмнө байгуулах урьдчилсан нөхцөлийг хангах үүднээс болон тус гэрээг хянасны үндсэнд, Хувьцаа эзэмшигчид нь ХасБанкинд ЕСБХБ-тай Фреймворк гэрээ байгуулах зөвшөөрөл олгохыг дэмжсэн болохыг тус тус тэмдэглэв.

**ТОГТООХ нь:**

- ЕСБХБ болон ХасБанкны хооронд Фреймворк гэрээг энэхүү тогтоолд хавсаргасан байдлаар байгуулахыг зөвшөөрсүгэй.
- ТСН болон ХасБанкны Нэгтгэх гэрээг байгуулах өдөр эсхүл түүнээс өмнө Фреймворк гэрээг байгуулж, түүнд гарын үсэг зурахыг Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжавд даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА